

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Орхон аймгийн Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2022 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд
хийсэн хураангуй тайлан**

Аудитын код: ОРА-2023/59/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Эрдэнэт хот 2023 он</p>	<p>Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn Аудитын менежер: Б.Буян-Ундрах Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn Аудитор: Б.Азжаргал Утас: 70357955 Цахим хаяг: azjargalb@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна

Нэг. Дүгнэлт



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2023.02.16 № 23

танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН ЖАРГАЛАНТ
СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Д.НЯМДАВАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна. Анхан шатны баримтын бүрдэл хангах, түүнд хяналт хэрэгжүүлсэн байдал нь үр нөлөөгүй байгаа нь гүйцэтгэлийн үе шатанд хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнд илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэлээр илэрч байна.

Аудитын гол асуудал

Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 91 дүгээр “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай” тогтоолын дагуу Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаалаар төрийн болон орон нутгийн өмчит ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээл, сургалтын үйл ажиллагааны зардлыг хувьсах зардлын дундаж нормативаар буюу гүйцэтгэлд суурилан төсвийг олгож эхэлсэн байна.

D:\my doc \alban bichig\2023-A4.doc

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 07 дугаар сарын 22-ний өдрийн А/259 "Заавар батлах тухай", 2022 оны 05 дугаар сарын 12-ний өдрийн А/170 "Заавар батлах тухай" тушаалуудын дагуу зарцуулалт хийсэн байна.

Гүйцэтгэлд суурилсан төсвөөр санхүүжилт олгохдоо 2022 оны эцсээр огцом нэмэгдүүлж, бараа материалын нөөц үүсгэх, сургалтууд он дамжин хэрэгжихэд хүргэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй төрийн аудитын албан хаагчид аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилт, 49 арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын даргатай байгуулж, хэрэгжилтийг 95.0 хувьтай гэж үнэлсэн байна.

Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөлд хичээлийн байрны хүчин чадлыг 640 хүүхдээр тооцсон боловч 518 хүүхэд суралцаж, улсын төсвөөс гүйцэтгэлээр санхүүжиж байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

	Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	132,859,316.66	161,818,230.43
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,942,160,443.77	2,946,287,880.06
	Нийт хөрөнгийн дүн	3,075,019,760.43	3,108,106,110.49
	Нийт өр төлбөрийн дүн	3,075,019,760.43	3,128,566,110.49
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,075,019,760.43	3,128,566,110.49
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,075,019,760.43	3,128,566,110.49
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,283,394,819.55	1,538,930,741.62
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,299,362,264.43	1,485,384,391.56
	Үйл ажиллагааны үр дүн	(15,967,444.88)	53,546,350.06
	Үйл ажиллагааны бус үр дүн	73,688,567.83	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(89,656,012.71)	53,546,350.06
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,566,236,273.72	1,558,525,345.86
	Тайлант оны үр дүн		(197,382,712.71)
	Эцсийн үлдэгдэл	3,272,402,473.14	3,128,566,110.49
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,262,421,067.55	1,413,919,800.00
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,151,114,367.55	1,397,393,192.85
	Үйл ажиллагааны ЦМГ	111,306,700.00	16,526,607.15
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	3,580,000.00	-
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	107,726,700.00	16,526,607.15
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	16,526,607.15
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	16,526,607.15
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	16,526,607.15
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,378,967,769.97	1,378,967,769.97
	Урсгал зардал	1,378,967,769.97	1,378,967,769.97
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1,400,512,500.00	1,400,512,500.00
	Улсын төсвөөс санхүүжих	1,151,917,700.00	1,151,917,700.00
	Орон нутгийн төсвөөс	248,594,800.00	248,594,800.00

Гурав. Аудитын илрүүлэлт

3.1 Төлбөрийн акт:

Илрүүлэлт: Багшийн хөгжлийг дэмжих, цахим хэрэглээний хүрээнд багш нарт ДАТА багц худалдан авсан бөгөөд журамд хамаарахгүй албан хаагчдад олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12.1-д “Энэ хуулийн 3.1-д заасан

этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.1-т “гар утасны зардал”, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн цахим хэрэглээний зардлыг төлөвлөх хуваарилах заавар”-ын 2.4-д “дата багцыг сонгосон нөхцөлд цахим хэрэглээний нийт зардлыг нийт үндсэн багш (бүлгийн болон хөгжим, биеийн тамирын багшийн нийт тоо) тоонд хувааж тухайн хугацаанд ашиглах цахим хэрэглээний зардлын нэгжийг тооцно” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй /гэж заасныг зөрчсөн” гэж заасантай нийцэхгүй байна.

3.2 Албан шаардлага:

Илрүүлэлт: Тайлант онд 3,560.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж бэлтгэхдээ зах зээлийн үнээс өндөр үнээр бэлтгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.2-д “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” гэж заасантай нийцэхгүй байна.

3.3 Зөвлөмж

Илрүүлэлт: Бараа үйлчилгээний бусад зардлаас 3,028.0 мянган төгрөгийн шатах тослох материал худалдан авахдаа гэрээ хэлцэлгүй хөрөнгө зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.2-д “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 34.3.2-д “тухайн хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдсон аливаа гэрээ байгуулагдаагүй” гэж заасантай нийцэхгүй байна.

Зөвлөмж: Хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдсон гэрээ хэлцэл байгуулж, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангах.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орхон аймгийн Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургууль	3	6,828.7	1	240.0	1	3,560.7	1	3.028.0				
Дүн	3	6,828.7	1	240.0	1	3,560.7	1	3.028.0				

Орхон аймгийн Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан
төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй тайлан

							1	3.028.0				
			1	240.0	1	3,560.7	1	3.028.0				

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	Орхон аймгийн Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургууль	1	1			1			
	НИЙТ	1	1			1			

